



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 63

Эрдэнэт

Анхдагч илгээлтийн эздийн өдөр бий
болгох тухай

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Жил бүрийн 8 дугаар сарын 12-ны өдрийг “Анхдагч илгээлтийн эздийн өдөр” болгож, орон нутгийн хэмжээнд тэмдэглэх тэмдэглэлт өдрөөр тогтоосугай.

2.“Анхдагч илгээлтийн эздийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр тухай бүр батлуулж, холбогдох төсөв хөрөнгийг тухайн жилийн төсөвт тусгаж, бэлтгэл зохион байгуулалтыг ханган тэмдэглэж байхыг аймгийн Засаг дарга бөгөөд Эрдэнэт хотын захирагч /С.Дангаасүрэн/-нд даалгасугай.

ДАРГА



Б.МЯГМАРСҮРЭН

C:\Togtool \-A4 doc

00100146